



ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Л.БУЯНТОГТОХ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.21 № 01/32 ДУА-2017/119/СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Эрдэнэдалай сумын сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад байрны хүүхдэд нийт 52,127,650.00 төгрөгийн хоолны материалыг олгож, тооцоог цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг нормоор бодоогүй, нийт дүнгээр зардалд тайлагнаж, хүнсний материалыг хяналтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад /1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг/, заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Хүнсний бүтээгдэхүүнийг зарцуулахдаа холбогдох стандарт, журмын дагуу насны ангиллаар хүүхдийн хоногийн хоолны хэрэгцээг хангах, жишиг нормоор тооцоог бодож зарцуулалтанд хяналт тавьж хэвших.

0000000064

2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 04 дүгээр сарын 25-ны дотор ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Сургуулийн захирал /Л.Буянтогтох/, нягтлан бодогч /Д.Ууганбаяр/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АХЛАХ ШИНЖЭЭЧ

Д.ИХБАЯР


ЗАХИРАЛ

Л.БУЯНТОГТОХ

НЯГТЛАН БОДОГЧ

Д.УУГАНБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.